

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАНТАЙ ХОЛБООТОЙГООР
ХУУЛЬ ХООРОНДЫН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ
АРИЛГАХ ЗОРИЛГООР ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН
БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны өөрчлөлттэй холбоотойгоор 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар үзэл баримтлалын хувьд сонгуулийн эрх зүй, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор дараах зохицуулалтууд тусган батлагджээ. Үүнд:

1.2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэсэн өөрчлөлтийг үндэслэн сонгуулийн тогтолцоо, сонгуульд нэр дэвшүүлэх, санал авах, дүн гаргах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт;

2.Сонгуульд оролцож буй нам, эвсэл нэр дэвшигчдээс сонгуульд зарцуулах зардлыг бодитой бууруулж, тэгш өрсөлдөх боломжийг нэмэгдүүлсэн зохицуулалт;

3.Сонгуулийн зардлын хяналттай, нээлттэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлсэн зохицуулалт;

4.Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны болон онцолбол сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдал, сонгогчдын нэрийн жагсаалтад хяналт тавих боломж бүрдүүлсэн зохицуулалт зэрэг болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 47 дугаар тогтоол батлагдсан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан сонгуулийн зардлын ил тод,

хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангах, сонгуулийн холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт энэхүү тогтоолоор даалгажээ.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай байна. Тухайлбал:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2019 онд батлагдсан. Тус хуульд заасан хориглосон хэм хэмжээтэй шууд холбоотойгоор 2020 онд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд “Сонгуулийн хууль тогтоомж зөрчих” нийт 36 төрлийн үйлдлийг зөрчилд тооцохоор хуульчилжээ. Энэ хүрээнд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16.7 дахь хэсэгт “харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан” үйлдлийг зөрчилд тооцохоор заасан байна.

Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.7 дахь заалтыг “хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх;” болгож, мөн тус хуулийн 66 дугаар зүйлийн 66.13.3 дахь заалтыг “саналын хуудсанд тэмдэглэсэн санал, саналын хуудасны зураг авах, дүрс бичлэг хийх, шууд дамжуулах зэрэг үйлдэл гаргах;”-ыг хориглоно гэж тус тус өөрчилсөн тул эдгээр заалттай Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 30.2 дахь хэсгийг нийцүүлж, хууль хоорондын зөрчлийг арилгах нь зүйтэй байна.

2.Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан. Гэвч Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заажээ.

Дээрх 2 заалт нь сонгуулийн үеэр эрх бүхий албан тушаалтан энэ төрлийн гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад тодорхойшүй байдал үүсгэж байгаа тул тус асуудлыг шийдвэрлэж хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлд нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгааг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 35.2-т “Зөрчил болон гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл хэргийн болон зөрчлийн газарт нотлох баримттай нь баривчилснаас бусад тохиолдолд эрүүгийн хариуцлагад татах буюу эрүүгийн хэрэг үүсгэх, баривчлах, цагдан хорих, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглох”-оор тодорхой хуульчилсан. Гэвч Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох хуульд заасны дагуу бүртгэгдэж нэр дэвшигчийн үнэмлэх авсан нэр дэвшигчийг цагдан хорьсон тохиолдол гарсан. Шүүхээс нэр дэвшигчийг цагдан хорьсон талаарх үндэслэлээ тайлбарлахдаа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан. Уг харилцааг гагцхүү уг хуулиар зохицуулдаг тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос зөвшөөрөл авах шаардлагагүй” гэсэн тайлбарыг өгдөг.

Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно.” гэж заасантай холбоотой юм.

Иймд сонгуульд нэр дэвшигчдийг тэгш, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх зорилгоор уг харилцааг нарийвчлан зохицуулж, хууль хэрэглээний хувьд зөрчилтэй, тодорхой бус байдлыг арилгах шаардлагатай байна.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлд хандив авахыг хориглосон хүн, хуулийн этгээдийг тодорхойлон хуульчилсан. Өөрөөр хэлбэл, сонгогддог нийтийн албан тушаалд нэр дэвшигч нь түүнд сонгогдохын тулд хууль бус хандив цуглуулах, хуульд зөвшөөрснөөс өөр арга хэлбэрээр, холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон хэмжээнээс илүү хэмжээгээр хөрөнгө босгож хууль бусаар сонгуульд өрсөлдөх нь өндөр хэмжээний авлига, албан тушаалын үндэс суурийг бүрдүүлэх нөхцөл болох тул түүнд ногдуулах хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд зааснаар арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоод өнгөрөх эсэх асуудлыг эргэн харж, хариуцлагыг чангатгах нь зүйтэй байна.

5.Төрийн албан тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухайд:

Монгол Улс 2012 оноос хойш бүх шатны сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийг хэрэглэхээс гадна сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хариуцлагыг нэмэгдүүлэх, аливаа субъектив нөлөөллөөс ангид чөлөөт, шударга сонгуулийг зохион байгуулах үүднээс бүх шатны сонгуулийн байгууллагыг гагцхүү төрийн албан хаагчдаас бүрдүүлж байна.

Ээлжит сонгуульд нийт 35-45 мянган төрийн албан хаагч 7-30 хоногийн хугацаанд ажилладаг бөгөөд энэ хугацаанд нь хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээтэй тэнцэхүйц зөвхөн нэг удаагийн урамшуулал тэдгээрт олгодог. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны нэг онцлог нь сонгуульд оролцогч бүх талаас тавих хяналт маш өндөр байдагтай холбоотойгоор 2016 оноос хойш бүх шатны сонгуулийн хороодыг бүрдүүлэхэд тодорхой хүндрэлүүд үүсч эхэлсэн. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч үндсэн ажлынхаа хажуугаар сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд өндөр ачаалалтай ажилладаг, үндэслэлтэй, үндэслэлгүй олон гомдлыг сонгуульд оролцогчдийн зүгээс байнга гаргадаг, энэ нь эргээд үндсэн ажил албан тушаалтай нь холбоотой эрсдэл үүсгэдэг, бага хэмжээний урамшуулал авдаг зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан сонгуулийн хороодыг бүрдүүлэхэд хүндрэл үүсч байна. Иймд сонгуулийг хуулийн дагуу, хэвийн зохион байгуулах зорилгоор сонгуулийн хороодод ажилласан төрийн албан хаагчдад тодорхой эрх зүйн хөшүүрэг бий болгох шаардлага тулгараад байна.

2020 оны Улсын Их Хурлын болон орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль, 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль, 2022, 2023 онд зохион байгуулагдсан нөхөн болон дахин сонгуулийн үеэр хууль хэрэглээний хувьд болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дээр дурдсан зарим хүндрэл, бэрхшээл гарсан бөгөөд цаашид эдгээр асуудлыг гаргуулахгүй байхаас сэргийлж холбогдох хуулийн төслийг боловруулах нь зүйтэй гэж үзлээ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, түүний үзэл баримтлал, зохицуулалтад нийцүүлэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиуд хоорондын зөрчил, давхардал, хийдэл арилна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөл батлагдснаар төсөвт нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг үр дагавар байхгүй болно.